


1 МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ


1.1 Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт

Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) өмнөх оны мөн үеэс **18 хувиар өсч 24.2 их наяд төгрөгт хүрлээ**. M2 мөнгөний жилийн өсөлтийн 13.7 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 5.0 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 0.9 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, 0.2 нэгж хувийг төгрөгийн харилцах, -1.9 нэгж хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлж байна. Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлт 0.04 хувиар өсөхөд иргэдийн төгрөгийн хадгаламж, нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Харин хувийн байгууллага болон иргэдийн төгрөгийн харилцах харилцах буурчээ.

Зураг 1-1: M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 18.0%-иар нэмэгдсэн байна.



Зураг 1-3: M2 мөнгө өмнөх сараас 0.04 хувиар өсөв.




1.2 Хадгаламж

Нийт хадгаламжийн хэмжээ 18.2 их наяд төгрөг байгаагаас 85.6 хувь буюу 15.6 их наяд төгрөг нь иргэдийн, 14.4 хувь буюу 2.6 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Нийт хадгаламжийн 25.2 хувь нь гадаад валютын хадгаламж байна. Үүнээс иргэдийн хадгаламжийн 22.1 хувийг, байгууллагын хадгаламжийн 43.3 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.


1.3 Мөнгөний нийлүүлэлтийн байршуулалт

Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл, Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 18.8 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн 5.4 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулсан M2 мөнгөний өсөлтийн 10.5 нэгж хувийг ГЦА, 7.5 нэгж хувийг ДЦА бүрдүүлж байна.

Зураг 1-2: Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 26.7%-иар өсчээ.



Зураг 1-4: M2 мөнгөний жилийн өсөлтийг ГЦА-ын өсөлт бүрдүүлж байна.



2 БАНКУУДЫН ЗЭЭЛ


2.1 Зээлийн өсөлт

Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс **4.8 хувиар буурч 17.1 их наяд төгрөгт хүрсэн** байна. Үүнээс хувийн байгууллагын зээл 6.0 хувиар буурч 7.9 их наяд төгрөгт, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 7.9 хувиар буурч 8.5 их наяд төгрөгт хүрчээ. Нийт зээлийн үлдэгдлийн 1.6 их наяд төгрөг буюу 9.4 хувь нь гадаад валютаар олгосон зээл байна.


2.2 Зээл олголт, эргэн төлөлт

Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 523.7 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдсөн зээл 328.4 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Шинээр олгосон зээлийн 7.2 хувь буюу 103.6 тэрбум төгрөгийг гадаад валютаар олгожээ.

Зураг 2-1: Нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар буурч 17.1 их наяд төгрөг болов.



Зураг 2-3: Тайлант сард 1,441.9 тэрбум төгрөгийн зээл олгогдож, 1,419.1 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдлөө.




2.3 Чанаргүй зээл


Чанаргүй зээлийн 74.5 хувийг, хугацаа хэтэрсэн зээлийн 78.6 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлж байна. **Чанаргүй зээлийн үлдэгдэл 2,005.0 тэрбум төгрөгт** хүрч өмнөх сартай харьцуулахад 2.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээлийн 11.9 хувь нь гадаад валютын зээл байна. Чанаргүй зээлийн 20.8 хувийг уул уурхай, 19.6 хувийг боловсруулах, 13.4 хувийг барилга, 10.4 хувийг үл хөдлөх, 7.6 хувийг худалдааны салбарын зээл тус тус эзэлж байна.

Зураг 2-2: Нийт зээлийн 11.8% нь чанаргүй зээл, 7.7% нь хугацаа хэтэрсэн зээл байна.

Тайлбар: * үйл ажиллагаа явуулж буй 12 банкаар



Зураг 2-4: Чанаргүй зээлийн 74.5% хувийн байгууллагын, 25.0 хувийг иргэдийн зээл байна.




Эх сурвалж: Монголбанк

2.4 Хувийн байгууллагын зээл

Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл тайлант сард 10.3 тэрбум төгрөгөөр өсчээ.

Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн сарын өөрчлөлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилан харуулбал, худалдааны салбарын зээл 45.1 тэрбум, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын зээл 25.4 тэрбум, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын зээл 5.9 тэрбум, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын зээл 5.5 тэрбум төгрөгөөр тус тус өсч, барилгын салбарын зээл 39.9 тэрбум, уул уурхайн салбарын зээл 24.3 тэрбум, санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарын зээл 9.2 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Тайлант сард хувийн байгууллагад 709.9 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 13.8 хувь буюу 97.9 тэрбум төгрөгтэй тэнцэх зээл гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-5: Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн дийлэнх хувийг худалдаа, барилга, боловсруулах болон уул уурхайн салбарын зээл бүрдүүлж байна.



Зураг 2-7: Тайлант сард хувийн байгууллагад худалдаа, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт дийлэнх зээл олгогдсон байна



*Цахилгаан хий, усан хангамж, газар тариалан, мэдээлэл холбоо, санхүү даатгал, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд


2.5 Иргэдийн зээл

Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 14.6 тэрбум төгрөгөөр өсчээ.


Иргэдийн зээлийг задалж авч үзвэл, өмнөх сараас ипотекийн зээлийн үлдэгдэл 5.1 тэрбум (МИК-д шилжсэн багцыг оруулснаар), цалин, тэтгэврийн зээлийн үлдэгдэл 24.7 тэрбум, хадгаламж барьцаалсан зээлийн үлдэгдэл 1.8 тэрбум төгрөгөөр тус тус өсч, худалдааны салбарын зээл 20.4 тэрбум, автомашины зээлийн үлдэгдэл 6.8 тэрбум, картын зээлийн үлдэгдэл 2.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Тайлант сард иргэдэд 679.7 тэрбум төгрөгийн зээл шинээр олгогдсоны 0.8 хувь нь гадаад валютаар олгогджээ.

Зураг 2-6: Иргэдийн зээлийн 43% (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар)-ийг орон сууцны зээл, 25%-ийг цалин тэтгэврийн зээл бүрдүүлжээ.



Зураг 2-8: Тайлант сард иргэдэд олгосон зээлийн ихэнх хувийг хадгаламж барьцаалсан болон цалин, тэтгэврийн зээл эзэлж байна.



*ХАА, газар тариалан, боловсруулах, цахилгаан хий, усан хангамж, тээвэр агуулах, үйлчилгээ, мэдээлэл холбоо, мэргэжлийн ШУ, захиргаа, төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарууд

Эх сурвалж: Монголбанк

3 ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


3.1 Ипотекийн зээлийн үлдэгдэл

2021 оны 1 дүгээр сарын байдлаар **100,561 зээлдэгч нийт 4,933.1 тэрбум төгрөгийн** ипотекийн зээлтэй байна. Үүнээс хөтөлбөрийн эх үүсвэрээр 69,871 зээлдэгч 3,656.8 тэрбум төгрөгийн зээл авсан. Ипотекийн зээлийн үлдэгдлийн 74.3 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 22.0 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 3.7 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна.


3.2 Орон сууцны байршил

Нийт **ипотекийн зээлийн 16.9 хувь буюу 834.7 тэрбум төгрөгийн зээл орон нутагт** ногдож байна. Орон нутгийн ипотекийн зээл¹-ийн 75.4 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 22.3 хувь нь банкны өөрийн эх үүсвэрээр, 2.3 хувь нь бусад эх үүсвэрээр олгогджээ.

Зураг 3-1: Ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт 6.6%-д хүрэв.



Зураг 3-3: Нийт зээлийн 16.9% буюу 834.7 тэрбум төгрөг орон нутагт ногдож байна.



3.3 Ипотекийн зээлийн чанарын үзүүлэлт

Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн **94.2 хувь нь хэвийн**, 2.4 хувь нь хугацаа хэтэрсэн, 3.4 хувь нь чанаргүй зээл байна. Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 52.1 хувийг хөтөлбөрийн зээл, 47.2 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 0.7 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.

3.4 Эх үүсвэр

Тайлант сард **652 зээлдэгчид 53.2 тэрбум төгрөгийн** ипотекийн зээл шинээр олгосон бөгөөд үүний 59.3 хувийг хөтөлбөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна.

Зураг 3-2: Өмнөх сараас хугацаа хэтэрсэн зээл 11.0 тэрбум төгрөгөөр буурч, чанаргүй зээл 24.3 тэрбум төгрөгөөр өсчээ.



Зураг 3-4: Тайлант сард шинээр 652 зээлдэгчид ипотекийн зээл шинээр олгогджээ.



Эх сурвалж: Монголбанк

¹ Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.


3.5 Ипотекийн зээлийн хүү

Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 2.7 нэгж хувиар буурч, өмнөх сараас 0.3 нэгж хувиар өсч 8.8 хувьд хүрсэн байна.


3.6 Барьцаа хөрөнгө

Ипотекийн зээлээр борлуулагдсан орон сууцны 88.7 хувийг 80 хүртэлх мкв талбайтай байр бүрдүүлж байна.

Зураг 3-5: Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 8.8 хувьтай байна.



Зураг 3-6: Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээ талбайн хэмжээгээр




3.7 Орон сууцнууд ашиглалтад орсон оноор

Ипотекийн зээлээр борлуулагдсан орон сууцны 75.1 хувийг 2011 оноос хойш баригдсан орон сууц бүрдүүлж байгаа бөгөөд энэ нь нийт ипотекийн зээлийн 79.9 хувийг эзэлж байна.


3.8 Зээлдэгчдийн орлогын тархалт

2.5 сая төгрөг хүртэлх өрхийн орлоготой иргэд нийт зээлдэгчдийн 72.4 хувийг, нийт зээлийн үлдэгдлийн 58.2 хувийг тус тус бүрдүүлж байна.

Зураг 3-7: Ипотекийн зээлээр борлуулагдсан орон сууцны 75.1 хувийг 2011 оноос хойш ашиглалтад орсон орон сууц бүрдүүлж байна.



Зураг 3-8: Ипотекийн зээл авсан зээлдэгчийн орлогын тархалт




Эх сурвалж: Монголбанк

4 ХҮҮ

4.1 Шинээр татсан хадгаламжийн хүү

Шинээр татсан **төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 2021 оны 1 дүгээр сарын байдлаар 7.9 хувь**, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 2.0 хувь байна. Төгрөгийн хадгаламжийн ЖДХ өмнөх оны мөн үеэс 2.7 нэгж хувиар буурч шинээр татсан хугацаатай хадгаламжийн хүү 9.2 хувь, хугацаагүй хадгаламжийн хүү 4.3 хувь байна.


Зураг 4-1: Шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх сараас 0.4 нэгж хувиар буурчээ.




4.2 Шинээр олгосон зээлийн хүү

Тайлант сард **шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ 15.4 хувь**, гадаад валютын зээлийн ЖДХ 9.3 хувь болж, шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү өмнөх оны мөн үеэс 1.5 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна. Иргэдэд 648.1 тэрбум төгрөгийн зээл олгосноос 63.3 хувь нь 2 хүртэлх жилийн хугацаатай байна.


Зураг 4-2: Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү 15.4% байна.



Зураг 4-3: Шинээр татсан хугацаатай хадгаламжийн хүү 9.2%, хугацаагүй хадгаламжийн хүү 4.3% байна.



Зураг 4-4: Шинээр олгосон зээлийн хүүний тархалт



Эх сурвалж: Монголбанк


4.3 Үлдэгдлээр хадгаламжийн хүү

Нийт төгрөгийн хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ 9.8 хувьтай байна. Харин нийт гадаад валютын хадгаламжийн ЖДХ 3.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар буурав. Хадгаламжийн үлдэгдэлд ЖДХ иргэдийн төгрөгийн хадгаламжийн хувьд 10.1 хувь, гадаад валютын хадгаламжийн хувьд 4.0 хувьтай байгаа бол хувийн байгууллагын төгрөгийн хадгаламжийн хувьд 8.6 хувьтай байна.

4.4 Хүүний зөрүү

Тухайн сард шинээр олгосон төгрөгийн зээл болон тухайн сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүүний зөрүү 2020 оны 12 дугаар сарын байдлаар 7.5 нэгж хувьд хүрэв.

Зураг 4-5: Үлдэгдлээр жигнэсэн төгрөгийн хадгаламжийн хүү 9.8% байна.




4.5 Зээлийн үлдэгдлээр хүү


Төгрөгийн зээлийн үлдэгдэлд ЖДХ 16.5 хувь, гадаад валютын зээлийн ЖДХ 10.3 хувьтай байна. Үүнээс иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 17.7 хувьтай, гадаад валютын зээлийн ЖДХ 12.3 хувьтай байна. Хувийн байгууллагын зээлийн ЖДХ 15.1 хувьтай, гадаад валютын зээлийн хүү 10.3 хувьтай байна.

Зээлийн үлдэгдлийн дийлэнхийг 2-5 жилийн хооронд төлөгдөж дуусах зээлүүд эзэлж байна.


Зураг 4-6: Иргэдийн зээлийн үлдэгдлийн хүү өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар бууцрээ.



Зураг 4-7: Хадгаламж, зээлийн хүүний зөрүү өмнөх оноос 1.1 нэгж хувиар өсчээ.



Зураг 4-8: Зээлийн үлдэгдэл, хугацаагаар



5 ИНФЛЯЦ

5.1 Улсын инфляц

Хэрэглээний үнийн улсын индекс 2021 оны 1 дүгээр сарын байдлаар **жилийн 2.4 хувь**, сарын инфляц 1 хувь байна. Жилийн инфляцыг авч үзвэл 2.1 нэгж хувийг хүнсний барааны бүлэг, 0.3 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнийн өсөлт бүрдүүлж байна.


Зураг 5-1: Улсын жилийн инфляц 2.3 хувьтай байна.



5.2 Улаанбаатар хотын инфляц

Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс **1 дүгээр сарын байдлаар 1.3 хувь** байгаа ба 1.9 нэгж хувийг бараа, хүнсний -0.6 нэгж хувийг хүнснээс бусад барааны үнийн өсөлт бүрдүүлж байна. Хүнсний барааны бүлгийн үнэд мах, махан бүтээгдэхүүний бүлгийн үнийн өсөлт, хүнснээс бусад барааны үнэ буурахад хатуу түлшний үнэ болон тээврийн бүлгийн үнэ буурсан нь нөлөөлжээ.

Зураг 5-2: УБ хотын жилийн инфляц 1.9 хувьд хүрэв.




Эх сурвалж: УСХ

6 ХАНШ

6.1 Ам.долларын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сарын эцсийн байдлаар 2,850.12 төгрөгт хүрсэн нь **өмнөх сарын эцсээс 0.2 хувиар**, өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар суларсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 2,849.82 төгрөг байв.


Зураг 6-1: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт.



6.2 Хятадын юанийн ханш

Төгрөгийн юаньтай харьцах сарын эцсийн ханш **өмнөх сараас 4.9 хувиар суларч** 441.09 төгрөгт хүрэв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 439.12 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 441.53 төгрөг байлаа.

Зураг 6-2: Төгрөгийн юаньтай харьцах ханшийн өөрчлөлт.



Эх сурвалж: Монголбанк